

2002–2005 ОНУУДЫН ЗЭЭЛИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН СУДАЛГАА

Оршил

Эдийн засгийн өсөлт хөгжилтийг тодорхойлдог гол хүчин зүйлсийн нэг бол банкны салбарын зээлжүүлэлт юм. Монгол улсад 2 шатлалт банкны систем үүсч хөгжсөнөөс хойш даруй 14 жил өнгөрлөө. Хөгжлийнхөө эхний үе шатанд арилжааны банкууд иргэд, аж ахуйн нэгж болон улсын үйлдвэрийн газруудад бололцооныхоо хэмжээгээр зээл олгож эдийн засгийн өсөлт хөгжилтөд тус нэмэр оруулж байсан хэдий ч төрөөс банкны үйл ажиллагаанд оролцох, зарим банкны удирдлагын сул тал, зах зээлийн мэдрэмж муу, банкны ажилтнуудын мэдлэгийн ур чадварын дутмаг байдал, зээлдэгчдийн хариуцлагагүй хандлага болон хүүний өндөр түвшин, хугацааны богино зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалан олгосон зээлүүд нь хугацаандаа эргэж төлөгдөлгүй муу зээлийн хэлбэрт шилжин улмаар банкуудыг дампуурлын байдалд хүргэсэн түүхтэй.

Банкуудын найдвартай ажиллагааг хангах үүднээс Монголбанк банкуудад тавих хяналт шалгалтаа чангатгаж, зээлийн өрийн үлдэгдэлд хязгаарлалт тавих, заавал байлгах нөөцийн хэмжээг тогтоон мөрдүүлэх зэрэг хэд хэдэн арга хэмжээг авч ирсэн ба банкны бүтцийн өөрчлөлтийн хүрээнд хууль, журмын өөрчлөлтүүд гарсан нь банк байгуулсан нэрээр өөр бизнес эрхлэх мэтийн банкны найдвартай үйл ажиллагааг сааруулах боломжийг ерөнхийд нь таслан зогсоосон. 1996-1999 оны банкны хямралын улмаас төлбөрийн чадваргүй болсон банкуудыг татан буулгаж, нэг ёсны банкны салбарыг цэвэржүүлсэн нь иргэдийн банкинд итгэх итгэлийг нэмэгдүүлэх нэг гол хүчин зүйл болсон. Түүнээс гадна банкууд өөрсдийн зээл олголтын тусгай журамтай болж, зээл олголтыг чангатгасан нь зээлийн эрсдэлийг багасгаж, надвартай үйл ажиллагааны эхлэлийг тавьсан юм.

Сүүлийн жилүүдэд банкны салбарт чухал олон өөрчлөлтүүд гарсаны нэг нь чанаргүй зээлийн хэмжээ эрс буурч, зээл олголтын хэмжээ нэмэгдсэн хэдий ч бодит эдийн засагт хөрөнгө оруулалт хийх, ялангуяа зээлийн хүү дорвитой буурахгүй, дунд болон урт хугацааны зээлийн тал дээр дутмаг байгаа байдал ажиглагдаж байна.

Энэ судалганы ажлын хүрээнд үйл ажиллагаа явуулж буй 17 банкны зээлийн тайлангын үзүүлэлтүүдийг 2002, 2003, 2004, 2005 онуудын 3 дугаар улирлын байдлаар авч үзлээ. 2005 оны 3 дугаар улирлын зээлийн өрийн үлдэгдэл, зээл олголт, төлөлт, хугацаа, хүү болон эдийн засгийн ямар салбарт хөрөнгө оруулалт хийж байгааг 2002, 2003, 2004 онуудтай харьцуулсан судалгаа хийлээ.

Зээлийн өрийн үлдэгдэл

Банкны салбараас аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон зээлийн өрийн үлдэгдэл 2005 оны 3 дугаар улиралд 774.6 тэрбум төгрөгт хүрэв. Энэхүү үзүүлэлт 2002 оны мөн үеэс 3.9 дахин, 2003, 2004 оныхоос 2.2, 1.3 дахин тус тус өссөн нь банкуудын санхүүгийн зуучлалын үйл ажиллагааны хүрээ хэр зэрэг өргөжин тэлснийг харуулж байна.

Хүснэгт 1. Зээлийн өрийн үлдэгдэл, өмчийн хэлбэрээр (тэрбум төгрөг, хувиар)


Салбар	2005-III дүн	Хувийн жин	2005-III 2004-III	2005-III 2003-III	2005-III 2002-III
Улсын байгууллага	53.4	6.9	331.7	211.9	335.8
Хувийн хэвшил	399.2	51.5	122.4	202.5	324.3
Гадаад байгууллага, хамтын үйлдвэр	31.3	4.0	126.7	204.6	391.3
Олон нийтийн байгууллага	1.6	0.2	177.8	200.0	800.0
Иргэд	289.1	37.3	146.0	254.3	586.4
Нийт	774.6	100.0	136.9	220.0	394.2

Банкуудын нийт зээлийн өрийн үлдэгдэлд хувийн хэвшлийн зээл дийлэнх буюу дунджаар 57 хувь, иргэд 32.4 хувь, улсын байгууллага 6.2 хувь, гадаад байгууллага, хамтын үйлдвэр 4.2 хувь, олон нийтийн байгууллага 0.2 хувийг тус тус эзэлж байна. Үүнээс харахад банкууд хувийн хэвшил, иргэдэд түлхүү зээл олгожээ. Иргэд, хувийн хэвшилд олгосон зээлийн өрийн үлдэгдэл 2002 оны 3 дугаар улирлаас 5.8, 3.2 дахин нэмэгджээ. Сүүлийн жилүүдэд банкууд тухайлбал, Хөдөө аж ахуй, ХАС банкууд бичил зээлийн үйлчилгээг зах зээлд нэвтэрүүлэн, амжилттай хэрэгжүүлж байгаатай холбоотой юм.

Олон нийтийн байгууллагын зээл 2005 оны 3 дугаар улирлын байдлаар 1.6 тэрбум төгрөгт хүрсэн нь 2002 оныхоос 8 дахин, 2003 оныхоос 2 дахин, 2004 оныхоос 1.7 дахин өссөн үзүүлэлттэй байна. Гэвч олон нийтийн байгууллагад олгосон зээлийн хэмжээ нийт зээлд эзлэх жин нь хамгийн бага буюу 0.2 хувь байна.

Улсын байгууллагын зээлийн өрийн үлдэгдэл 2002 оноос 3.3, 2003 оноос 2.1, 2004 оноос 3.3 дахин өссөн ба нийт зээлд эзлэх хувь 8.1-ээс 6.9 хувь болж буурчээ. Энэ нь төрийн мэдэлд байсан улсын үйлдвэр, газруудыг хувьчилснаас улсын байгууллагын тоо цөөрсөнтэй холбоотой байж болох талтай. Банкууд ТЭЦ-2,4, УБ ЦТС, Говь, Төмөр зам, Эрдэнэт, Автобус-2, Баянзүрх дүүргийн эмнэлэг, Тамга тэмдгийн үйлдвэр, Шарын гол ХК, Хөтөлийн цемент шохой, Сүү ХК, Дарханы цахилгаан станц, Дарханы дулааны дамжуулах сүлжээ, Баян-Өлгийн эрчим хүч, Хөвсгөл дулаан ХХК, Геологи судалгааны төв гэх мэт улсын байгууллагуудад зээлийг олгосон байна. Улсын байгууллагын зээлийн өрийн үлдэгдэл 2002, 2004 онуудад ижил 3.3 дахин өссөн, 2004 оны 3 дугаар улирлыг 2002 оны мөн үетэй харьцуулахад 9.1 тэрбум төгрөг буюу 36.1 хувиар буурсан нь банкууд уг салбарт зээлийг харьцангуй багаар санхүүжүүлэх сонирхолтой байна. Цаашид банкууд эдийн засгийн өсөлт, үндэсний үйлдвэрлэл, үр ашигтай хөрөнгө оруулалтыг дэмжих зорилгоор хүү багатай, урт болон дунд хугацааны зээлийг олгох шаардлагатай байна.

Зураг 1. Нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь хэмжээ, өмчийн хэлбэрээр (хувиар)



Сүүлийн 4 жилийн 3 дугаар улирлын байдлаар зээлийн өрийн үлдэгдлийн хэмжээгээр Хөдөө аж ахуй, Худалдаа хөгжил, Голомт, Анод банкууд тэргүүлж байна. Энэ нь дээрх банкууд банк санхүүгийн зах зээл дээр зээлийн идэвхтэй, зөв бодлого хэрэгжүүлж байгаа ба Худалдаа хөгжлийн банк 2002 он, Хөдөө аж ахуйн банк 2003 онд тус тус хувьчилагдаж банкууд эзэнтэй болсонтой холбоотой юм.

Мөн Улаанбаатар хотын банкны зээлийн өрийн үлдэгдэл 2002 оноос 6.6, 2003 оноос 5.8, 2004 оноос 4.2 дахин (банкны удирдлагын бүтэц өөрчилөгдсөн), ХАС банкных 2002 оноос 7.2, 2003 оноос 3.8, 2004 оноос 1.9 дахин (бичил зээлийг шинээр нэвтрүүлсэн), Хадгаламж банкных 2002 оноос 4.8, 2003 оноос 2.1, 2004 оноос 1.2 дахин (зээлийн хязгаарлалтыг нь 2003 оны 7 сараас зогсоосон), Капитал банкных 2002 оноос 6.1, 2003 оноос 2.5, 2004 оноос 2.3 дахин тус тус нэмэгдсэн нь бусад банкуудын өсөлтөөс илүү байна. Тайлант улирлын байдлаар банкуудын зээлийн өрийн үлдэгдэл 2002 оны мөн үеэс дунджаар 3.8 дахин, 2003, 2004 оныхоос 2.1, 1.4 дахин тус тус өсчээ.

Харин Интер, Тээвэр хөгжлийн банкны зээлийн өрийн үлдэгдэл 2003 оноос хойш буурсан, Менатеп, Эрэл банкуудын зээлийн багц 2004 оноос хойш онцын өөрчлөлт, хөдөлгөөнгүй байгаа нь банк санхүүгийн зах зээл дээр хэрхэн үйл ажиллагаа явуулж байгааг илтгэж байна. Тухайлбал, Менатеп банкны зээлийн өрийн үлдэгдэл 1.8 тэрбум төгрөг нь чанаргүй зээлд ангилагдаж байна. Уг зээлийг хувийн хэвшлийн боловсруулах үйлдвэрийн салбарт олгожээ.

Хүснэгт 2. Банкуудын зээлийн өрийн үлдэгдэл (тэрбум төгрөг, хувиар)

Банкууд	2002-III	2003-III	2004-III	2005-III	2005-III	2005-III
---------	----------	----------	----------	----------	----------	----------

	дүн	Дүн	дүн	дүн	2002-III	2003-III	2004-III
Анод	17.4	45.9	101.1	95.7	549.9	208.5	94.7
Голомт	36.2	55.6	82.0	110.6	305.5	198.9	134.8
Зоос	14.5	24.2	35.1	57.9	399.2	239.2	165.1
Интер	3.4	8.0	8.4	6.7	195.6	83.1	79.0
Капитал	2.5	6.0	6.7	15.5	618.2	257.6	230.3
Капитрон	9.1	17.0	19.3	27.8	305.4	163.5	144.3
Кредит	3.9	4.5	7.7	10.7	274.5	237.9	139.9
Менатеп	1.7	15.0	1.8	1.8	107.1	12.1	101.1
Монгол Шуудан	14.4	28.5	41.2	57.5	399.6	201.9	139.7
Тээвэр Хөгжил	3.9	6.2	7.7	4.9	125.5	78.9	63.7
Улаанбаатар	6.7	7.6	10.6	44.8	668.7	589.5	422.3
Хадгаламж	5.1	11.8	20.9	24.9	488.2	211.0	119.1
Хөдөө Аж Ахуй	20.7	48.5	77.0	119.1	575.5	245.6	154.8
Хас	4.7	8.8	17.8	34.1	725.7	387.6	191.9
Худ/хөгжил	49.3	60.4	85.1	113.7	230.6	188.2	133.6
Чингис Хаан	-	-	38.6	44.0			113.8
Эрэл	3.0	4.1	4.9	5.0	165.7	121.2	101.8
Нийт	196.5	352.1	565.8	774.6	394.2	220.0	136.9

* Чингис хаан банк 2003 оны 10 сараас банкны үйл ажиллагаа явуулж эхэлсэн.

Сүүлийн 4 жилийн дунджаар нийт зээлийн өрийн үлдэгдлийн 18.0 хувийг Худалдаа хөгжлийн банк, 15.7 хувийг Голомт, 13.3 хувийг Хөдөө аж ахуй, 13.0 хувийг Анод, 7.5 хувийг Шуудан, 7.0 хувийг Зоос, 25.5 хувийг бусад банкууд (11) эзэлж байна. Энэ нь дээрх 6 банкинд нийт зээлийн өрийн үлдэгдлийн 74.5 хувь нь ноогдож байгаа нь зээл хэдхэн том банкуудад төвлөрч, зээлийн салбарт эзэлж буй байр суурийг харуулж байна. Дээрх 6 банкыг банк бүрээр нь авч үзвэл, Худалдаа хөгжил, Голомт банкуудын нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувийн жин 2002 оны 3 дугаар улирлаас 2005 оны мөн үе хүртэл 10.4, 4.1 нэгжээр буурч, Анод, Шуудан, Зоос банкных дээрх хугацаанд өсөлт, бууралттай байна. Нийт зээлийн өрийн үлдэгдэлд Хөдөө аж ахуйн банкны эзлэх хувийн жин өссөн үзүүлэлттэй байна. Дээрхээс харахад том банкуудын нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь хэмжээ буурч байгаа нь банк хоорондын өрсөлдөөн чангарч, банкны үйлчилгээ чанаржиж, банкны олон төрлийн үйлчилгээ нэмэгдсэнтэй холбож болох юм. Тухайлбал, ХАС, Хадгаламж, Чингис хаан, Улаанбаатар хотын банк сүүлийн жилүүдэд бусад жижиг банкуудыг бодвол банк санхүүгийн зах зээлд үйл ажиллагаагаа идэвхжүүлснээр нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хэмжээ нэмэгдсээр байна.

Хүснэгт 3. Нийт зээлд эзлэх банкуудын зээлийн өрийн үлдэгдэл (хувийн эсин)

Банкууд	2002-III	2003-III	2004-III	2005-III	Дундаж
---------	----------	----------	----------	----------	--------

	Хувь	хувь	Хувь	хувь	
Анод	8.9	13.0	17.9	12.4	13.0
Голомт	18.4	15.8	14.5	14.3	15.7
Зоос	7.4	6.9	6.2	7.5	7.0
Интер	1.7	2.3	1.5	0.9	1.6
Капитал	1.3	1.7	1.2	2.0	1.5
Капитрон	4.6	4.8	3.4	3.6	4.1
Кредит	2.0	1.3	1.4	1.4	1.5
Менатеп	0.9	4.3	0.3	0.2	1.4
Монгол Шуудан	7.3	8.1	7.3	7.4	7.5
Тээвэр Хөгжил	2.0	1.8	1.4	0.6	1.4
Улаанбаатар	3.4	2.2	1.9	5.8	3.3
Хадгаламж	2.6	3.4	3.7	3.2	3.2
Хөдөө Аж Ахуй	10.5	13.8	13.6	15.4	13.3
Хас	2.4	2.5	3.1	4.4	3.1
Худалдаа хөгжил	25.1	17.2	15.0	14.7	18.0
Чингис Хаан	-	-	6.8	5.7	3.1
Эрэл	1.5	1.2	0.9	0.6	1.0
Нийт	100.0	100.0	100.0	100.0	100.0

Монгол улсад үйл ажиллагаагаа явуулж буй банкуудын тоог боломжийн гэж Монголбанк¹ үздэг ба энэхүү тоог хэмжээнд нь барих, өсгөхгүйгээр байх бодлогуудыг авч хэрэгжүүлж байна. Үүний жишээ нь арилжааны банкны дүрмийн сангийн хэмжээг сүүлийн жилүүдэд шатлалтайгаар нэмэгдүүлж, өсгөж байгаа ба энэ шаардлагыг хангаж чадаагүй банкууд нэгдэх юм уу эсвэл татан буулгаж банк бус санхүүгийн байгууллага болгох зэрэг арга хэмжээг авч байна. Дүрмийн сангийн хэмжээг ийнхүү өсгөсөн нь нэг талаас банкуудын эрсдэлээ даах чадварыг нэмэгдүүлэх, банкны тогтвортой ажиллах, цаашид санхүүгийн зах зээл дээр хямрал гарахгүй байх нөхцлийг бүрдүүлэх, өрсөлдөөнийг сайжруулах ба нөгөө талаас банкны салбарт шинээр үйл ажиллагаа эрхлэх сонирхолтой бизнес эрхлэгчдийн тоог тодорхой хэмжээгээр багасгаж чанаржуулах нөлөө үзүүлэх зорилготой.

Монголбанкнаас 2006 оны 4 сарын 1-ны дотор арилжааны банкуудын дүрмийн сангийн доод хэмжээг 8 тэрбум төгрөг байхаар тогтоож өгсөн. Банкуудын дүрмийн сангийн доод хэмжээ 4 тэрбум төгрөгөөс 8 тэрбум төгрөг болж өсөхийн хирээр ялангуяа жижиг банкуудын хувьд шинэ эх үүсвэрийг зээл болгон байршуулах шахалт эрс нэмэгдэх нь жижиг банкуудын оршин тогтнох орон зай цаашид байх эсэхэд нөлөөлнө. Сүүлийн 4 жилийн дунджаар жижиг банкуудын нийт зээлийн өрийн үлэгдэлд эзлэх хувь 1.0 - 4.1 хувь байна.

2005 оны 3 дугаар улирлын байдлаар банкуудын үйлдвэрлэлийн зориулалтаар олгосон зээлийн өрийн үлдэгдэл 333.3 тэрбум төгрөгт хүрсэн нь 2002 оны мөн үеэс 232.2 тэрбум төгрөг буюу 3.3 дахин, 2003 оныхоос 173.3 тэрбум төгрөг буюу 2.1 дахин, 2004 оныхоос 48.0 тэрбум төгрөг буюу 16.8 хувиар тус тус өсчээ.


¹ Монголбанкнаас 2005 онд явуулсан Монгол улсын нийгэм, эдийн засаг, банк санхүүгийн байгууллагын хөгжил, үйл ажиллагааны талаархи түүвэр судалгаанд хамрагдсан иргэдийн 45.5 хувь нь банкуудын тоог боломжийн, 40.0 хувь нь олон гэж үзсэн байна.

Үйлдвэрлэлийн бус зориулалтаар олгосон зээлийн өрийн үлдэгдэл 2002 оны 3 дугаар улирлаас 345.7 тэрбум төгрөг буюу 4.6 дахин, 2003 оноос 249.2 тэрбум төгрөг буюу 2.3 дахин, 2004 оныхоос 160.7 тэрбум төгрөг буюу 1.6 дахин тус тус нэмэгдсэн байна. Анод, Голомт, Хөдөө аж ахуй, Худалдаа хөгжил, Шуудан, Зоос банкууд үйлдвэрлэлийн болон үйлдвэрлэлийн бус зориулалтаар олгосон зээлийн өрийн үлдэгдэл, эзлэх хувь хэмжээгээрээ бусад банкуудаас давамгайлж байна. Сүүлийн 2 жил болон 2002 онд Менатеп банк үйлдвэрлэлийн бус салбарт зээл олгоогүй байна.

Хүснэгт 4.Банкуудын зээлийн өрийн үлдэгдэл, салбараар (тэрбум төгрөг)

Банкууд	2002-III		2003-III		2004-III		2005-III	
	Үйлд-н	Үйлд-н бус	Үйлд-н	Үйлд-н бус	Үйлд-н	Үйлд-н бус	Үйлд-н	Үйлд-н бус
Анод	8.5	8.9	18.3	27.6	46.6	54.5	48.7	47.2
Голомт	19.8	16.4	31.7	23.9	42.1	39.9	58.4	52.5
Зоос	7.4	7.1	11.7	12.5	15.9	19.2	24.3	33.8
Интер	0.2	3.2	2.4	5.7	3.8	4.7	3.7	2.9
Капитал	1.2	1.3	2.7	3.3	2.7	4.0	8.0	7.4
Капитрон	4.4	4.7	7.3	9.7	8.6	10.7	8.5	19.4
Кредит	1.9	1.9	2.7	1.8	3.7	4.0	4.4	6.3
Менатеп	1.7	0.0	10.1	4.9	1.8	0.0	1.8	0.0
Монгол Шуудан	7.6	6.8	13.1	15.2	17.8	23.4	21.0	36.5
Тээвэр Хөгжил	1.8	2.2	2.4	3.8	1.5	6.2	0.6	4.3
Улаанбаатар	3.3	3.4	3.7	3.9	6.2	4.4	23.1	21.6
Хадгаламж	1.7	3.4	0.6	11.2	1.5	19.4	1.9	22.8
Хөдөө Аж Ахуй	2.8	17.9	8.0	40.6	50.3	26.7	35.9	83.3
Хас	0.7	4.0	0.6	8.3	1.4	16.4	4.9	29.3
Худ/хөгжил	35.8	13.6	42.1	18.3	55.1	30.0	60.9	52.9
Чингис Хаан	-	-	-	-	22.4	16.2	23.5	19.8
Эрэл	2.2	0.8	2.5	1.5	3.9	0.9	3.7	1.3
Нийт	101.0	95.6	160.0	192.1	285.3	280.6	333.3	441.3

Зураг 2.Нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь хэмжээ, салбараар



Банкууд үйлдвэрлэлийн бус салбарт арай илүү санхүүжилт хийх сонирхолтой байна. Энэ нь нэг талаас манай оронд сүүлийн жилүүдэд бий болсон байгаль, цаг уурын тааламжгүй нөхцөл байдлаас шалтгаалж хөдөө аж ахуй, газар тариалангийн бизнес

эрсдэлтэйд тооцогдож банкууд үйлдвэрлэлийн салбарт үйлдвэрлэлийн бус салбараас харьцангуй бага хэмжээний зээл олгож байсантай холбож болох юм. Банкууд үйлдвэрлэлийн бус салбар, түүн дотроо бөөний болон жижиглэнгийн худалдааг түлхүү санхүүжүүлж байна.

Хүснэгт 5. Банкуудын зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь, салбараар (хувиар)


Банкууд	2002-III		2003-III		2004-III		2005-III	
	Үйлд-н	Үйлд-н бус	Үйлд-н	Үйлд-н бус	Үйлд-н	Үйлд-н бус	Үйлд-н	Үйлд-н бус
Анод	4.3	4.5	5.2	7.8	8.2	9.6	6.3	6.1
Голомт	10.1	8.3	9.0	6.8	7.4	7.1	7.5	6.8
Зоос	3.7	3.6	3.3	3.6	2.8	3.4	3.1	4.4
Интер	0.1	1.6	0.7	1.6	0.7	0.8	0.5	0.4
Капитал	0.6	0.7	0.8	0.9	0.5	0.7	1.0	1.0
Капитрон	2.2	2.4	2.1	2.8	1.5	1.9	1.1	2.5
Кредит	1.0	1.0	0.8	0.5	0.7	0.7	0.6	0.8
Менатеп	0.9	0.0	2.9	1.4	0.3	0.0	0.2	0.0
Монгол Шуудан	3.9	3.5	3.7	4.3	3.1	4.1	2.7	4.7
Тээвэр Хөгжил	0.9	1.1	0.7	1.1	0.3	1.1	0.1	0.6
Улаанбаатар	1.7	1.8	1.0	1.1	1.1	0.8	3.0	2.8
Хадгаламж	0.9	1.7	0.2	3.2	0.3	3.4	0.2	2.9
Хөдөө Аж Ахуй	1.4	9.1	2.3	11.5	8.9	4.7	4.6	10.8
Хас	0.4	2.0	0.2	2.3	0.2	2.9	0.6	3.8
Худ/хөгжил	18.2	6.9	12.0	5.2	9.7	5.3	7.9	6.8
Чингис Хаан	-	-	-	-	4.0	2.9	3.0	2.6
Эрэл	1.1	0.4	0.7	0.4	0.7	0.2	0.5	0.2
Нийт	51.4	48.6	45.4	54.6	50.4	49.6	43.0	57.0

Нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх Худалдаа хөгжил, Голомт банкуудын үйлдвэрлэлийн салбарын зээлжүүлэлт 2002 оноос буурч, 2005 оны 3 дугаар улиралд 7.9, 7.5 хувь болжээ. Үүнийг бусад банкуудтай харьцуулахад үйлдвэрлэлийн салбарт эзлэх хувь өндөр байгаа нь цөөн тооны томоохон үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагад их хэмжээний зээл олгодогтой холбоотой юм. Хөдөө аж ахуй, Анод, Зоос, Голомт, Шуудан банкууд үйлдвэрлэлийн бус салбарт зээлжүүлэлтийг бусад банкуудаасаа харьцангуй

ихээр санхүүжүүлж байгаа нь нэг талаас зээлийн шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтэрүүлсэн, нөгөө талаас хөдөө орон нутагт өөрсдийн банкны олон салбар нэгжтэй хамаатай юм.

Зээлийн өрийн үлдэгдлийг бүтцээр нь авч үзвэл, 2005 оны 3 дугаар улиралд 34.4 хувийг бөөний болон жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засвар, 17.5 хувийг боловсруулах үйлдвэр, 9.7 хувийг барилгын салбар, 7.0 хувийг хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуй, загас барилт, 6.9 хувийг уул уурхай, олборлох үйлдвэр ба 24.5 хувийг бусад үлдсэн салбарууд тус тус эзэлж байна. Үүнийг өмнөх мөн үетэй харьцуулахад үйлдвэрлэлийн зориулалтын бүлгийн ихэнх салбарууд 0.1-6.3 нэгжээр буурсан байхад хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуй, загас барилт 1.6 нэгжээр нэмэгдсэн байна. Харин үйлдвэрлэлийн бус зориулалтын бүлгийн аялал, жуулчлал, зочид буудал, зоогийн газрын салбар 0.5 нэгжээр буурч, бусад салбарынх 0.3-4.9 нэгжээр өсчээ.

Зураг 3. Салбаруудад ноогдох нийт зээлийн өрийн үлдэгдэл (хувиар)



Банкууд бөөний болон жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засварын салбарт зээлжүүлэлт түлхүү хийдэг нь Зураг 3-аас харагдаж байна. Энэ нь ихэнх банкуудын нийт зээлийн дийлэнх нь хувийн, иргэдийн зээл эзэлдэгтэй холбоотой бөгөөд сүүлийн үед зээлийн шинэ бүтээгдэхүүн болох бичил санхүүгийн зээлийг нэвтэрүүлсэн, уг зээлийн зээлдэгчийн тоо өсөн нэмэгдэж байгаатай холбож болох юм. Цахилгаан, хий үйлдвэрлэл, усан хангамж, уул уурхай, олборлох үйлдвэрийн нийт зээлд эзлэх хувь хэмжээ 2002 оноос тогтмол буурч, 2005 оны 3 дугаар улиралд 2.0, 6.9 хувь болжээ. Үлдсэн бусад салбарынх өсөлт бууралттай байна.

Сүүлийн 4 жилийн хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуй, загас барилтын салбарын зээлжүүлэлтийг харьцуулахад 2002 онд хамгийн дээд түвшиндээ буюу нийт зээлийн өрийн үлдэгдлийн 12.9 хувийг эзэлж байсан ба 2003, 2004 онуудад даруй 7.0, 7.6 нэгжээр тус тус буурчээ. Энэ нь сүүлийн үед болсон гад зуд гэх мэт байгалийн бэрхшээлээс шалтгаалсан болох талтай. 2005 онд 7.0 хувь болсон байна. Харин барилгын салбарын зээлжүүлэлт 2003, 2004 онд огцом өсч, нийт зээлийн өрийн үлдэгдлийн 8.4, 16.0 хувийг эзэлж байсан нь сүүлийн 4 жилийн хамгийн дээд түвшин юм. Дээрхээс харахад 2003, 2004 онд хөдөө аж ахуйн салбарт болсон ган зуд гэх мэт байгалийн давагдашгүй хүчин

зүйлийн нөлөөллөөс шалтгаалан уг салбарын зээлжүүлэлт багасч, тус салбарын хөрөнгө оруулагчид барилга болон бусад салбарт санхүүжүүлэлт хийсэн байж болох талтай.

Дээрх зураг 3-аас харахад, үйлдвэрлэлийн бус бүлгийн Бусад гэдэг ангилалд зээлийн өрийн үлдэгдэл харьцангуй их байдаг нь энэ салбарт цалин, тэтгэвэр, өөрийн ажилчдад зориулсан зээл, нийгэм, бие хүнд үзүүлэх үйлчилгээ, хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн аж ахуй буюу иргэдийн хувийн хэрэгцээнд олгосон зээлийг оруулдагтай холбоотой юм. Хөдөө аж ахуй, ХАС, Хадгаламж, Худалдаа хөгжил, Монгол шуудан зэрэг хот хөдөөд олон салбар нэгжтэй том, жижиг зээл олгодог банкуудын энэ салбарын зээл их байна. Тухайлбал, 2005 оны 3 дугаар улирлын байдлаар Хөдөө аж ахуйн банк 36.2 тэрбум, Монгол шуудан 14.4 тэрбум, Хадгаламж 10.5 тэрбум, ХАС банк 12.1 тэрбум, Голомт 6.5 тэрбум, Худалдаа хөгжил 5.0 тэрбум төгрөгийн зээлийн өрийн үлдэгдэлтэй байна. Тухайлбал, бусад бүлэгт хамгийн их дүнтэй Хөдөө аж ахуйн банкны 36.2 тэрбум төгрөгийн 35.6 тэрбум төгрөг нь хугацаандаа байгаа зээл, 0.3 тэрбум төгрөг нь хугацаа хэтэрсэн зээл, 0.3 тэрбум төгрөг нь чанаргүй зээлд ангилагдаж байна. Хугацаандаа байгаа зээлийг задалж үзвэл, 11.8 тэрбум төгрөг нь цалингийн зээл, 8.8 тэрбум төгрөг нь тэтгэвэр, 8.0 тэрбум төгрөг нь орон сууцны, 3.6 тэрбум төгрөг нь хадгаламж барьцаалсан, 2.4 тэрбум төгрөг нь өөрийн ажилчдад, 1.0 тэрбум төгрөг нь лизингийн зээлд ноогдож байна.

Чанаргүй зээл

Банкны салбар эрүүлжин, банкуудын үйл ажиллагаа найдвартай болж, ард иргэд, байгууллагуудын банкинд итгэх итгэл нэмэгдэж байгаа ба үүний нэг илрэл бол 2005 оны 3 дугаар улирлын байдлаар банкны систем дэх зээл хадгаламжийн хэмжээ 1990 оноос хойшхи хугацаанд хамгийн өндөр түвшиндээ хүрсэн ба чанаргүй зээлийн хэмжээ 52.7 тэрбум төгрөг буюу нийт зээлийн өрийн үлдэгдлийн 6.8 хувийг эзэлж байна. Үүнийг 2000 оны мөн үетэй харьцуулахад 23.6 нэгжээр буурчээ.

Сүүлийн 4 жилийн дунджаар чанаргүй зээлийн хэмжээ 29.8 тэрбум төгрөг буюу нийт зээлийн өрийн үлдэгдлийн 6.2 хувийг эзэлж байна. 2005 оны 3 дугаар улирлын байдлаар чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувийг 2002, 2003, 2004 оны мөн үетэй харьцуулахад 1.0, 0.7, 0.9 нэгжээр тус тус өсч, 6.8 хувь болов.


Хүснэгт 6. Банкуудын зээлийн өрийн үлдэгдэлд чанаргүй зээлийн эзлэх хувь (тэрбум төг, хувиар)

	2002-III	2003-III	2004-III	2005-III	Дундаж
Нийт зээлийн өрийн үлдэгдэл	196.6	352.1	565.8	774.6	472.3
Чанаргүй зээл	11.4	21.5	33.7	52.6	29.8
эзлэх хувь	5.8	6.1	5.9	6.8	6.2

2005 оны 3 дугаар улирлын байдлаар нийт зээлийн өрийн үлдэгдлийн 90.3 хувь буюу 699.6 тэрбум нь хугацаандаа байгаа, 2.9 хувь буюу 22.3 тэрбум нь хугацаа хэтэрсэн, 1.9 хувь буюу 14.4 тэрбум нь хэвийн бус, 0.9 хувь буюу 7.0 тэрбум төгрөг нь эргэлзээтэй, 4.0 хувь буюу 31.2 тэрбум нь муу зээлд тус тус ангилагдаж байна. Өмнөх оны мөн үеийнхээс муу зээл 0.9 нэгж, хэвийн бус

зээл 0.5 нэгжээр өсч, хугацаандаа байгаа зээл 0.7 нэгж, хугацаа хэтэрсэн зээл 0.1 нэгж, эргэлзээтэй зээл 0.5 нэгжээр тус тус буурчээ. 2002, 2003 оны мөн үетэй харьцуулахад хугацаандаа байгаа зээл 1.6 нэгж (2002) ба 0.3 нэгж (2003), хугацаа хэтэрсэн зээл 0.4 (2003), муу зээл 0.3 нэгж (2002)-ээр тус тус буурч, бусад зээлүүд 0.1-0.8 нэгжээр өссөн үзүүлэлттэй байна.

Зураг 4. Нийт зээлийн өрийн үлдэгдэл, хувиар (зээлийн ангиллаар)



Чанаргүй зээл 2005 оны 3 дугаар улирлын байдлаар өмнөх оны мөн үеийнхээс 56.4 хувь буюу 19.0 тэрбум төгрөгөөр өссөн байна. Энэхүү өсөлтөд Интер, Капитрон, Улаанбаатар хотын банкнаас бусад банкны чанаргүй зээл өссөнөөс шалтгаалжээ. Тухайлбал, Капитал 1.8 дахин, Тээвэр хөгжил 2.0 дахин, Анод 2.4 дахин, Зоос 2.4 дахин, Кредит 2.5 дахин, Хөдөө аж ахуйн банк 63 дахин нэмэгджээ.

2003 оны 3 дугаар улиралтай харьцуулбал, ганц Капитрон банкны чанаргүй зээл 24.1 хувиар буурч, бусад банкуудынх 13.1 хувиас 26.0 дахин өссөн байна.

2005 оны 3 дугаар улирлыг 2002 оны мөн үетэй харьцуулахад 4.5 дахин буюу 41.2 тэрбум төгрөгөөр нэмэгджээ. Тухайлбал, Хөдөө аж ахуйн банк 172.8 дахин, Анод 95.7 дахин, Тээвэр хөгжил 57.8 дахин, Капитал 44.2 дахин, ХАС 26.7 дахин, Интер 17.9 дахин, Зоос 17.6 дахин тус тус өссөн байна.

Хүснэгт7. Банкуудын чанаргүй зээлийн өсөлт, бууралт (хувиар)

	<u>2005-III</u> 2002-III	<u>2005-III</u> 2003-III	<u>2005-III</u> 2004-III
Анод	9571.2	669.8	241.3
Голомт	225.2	253.4	113.5
Зоос	1755.6	361.5	235.5
Интер	1791.5	1194.3	75.2
Капитал	4420.7	236.9	178.0
Капитрон	-	75.9	69.4

Кредит	155.2	298.0	251.6
Менатеп	-	-	101.1
Шуудан	184.6	268.6	92.2
Тээвэр Хөгжил	5785.7	191.3	196.3
Улаанбаатар	242.7	250.0	77.7
Хадгаламж	-	-	137.8
Хөдөө Аж Ахуй	17282.8	2600.1	6307.2
Хас	2672.6	398.0	101.7
Худ/хөгжил	273.4	113.5	127.0
Чингис Хаан	-	-	-
Эрэл	1380.7	993.8	149.3
Нийт	459.9	245.1	156.4

Тайлант улирлын байдлаар Голомт, Интер, Менатеп, Монгол Шуудан, Улаанбаатар хотын, ХАС, Худалдаа Хөгжлийн банкны нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс буурсан байхад бусад банкных өссөн дүнтэй байна. Ялангуяа нийт зээлд эзлэх Чингис хаан банкны чанаргүй зээл өмнөх оны мөн үеэс 8.5, Анод 6.5, Хөдөө аж ахуй 6.5, Зоос 1.2 нэгжээр өсчээ. 2002, 2003, 2004 онтой харьцуулахад Капитрон, Менатеп, Хадгаламж, Худалдаа хөгжлийн банкны нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хэмжээ тогтмол буурч ирсэн ба Анод, Зоос банкных тогтмол өсч, бусад банкуудых өсөлт бууралттай байна. Харин Капитал банкны нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хувь 2003 оноос хойш тогтмол 0.5 хувьтай байна.

Сүүлийн 4 жилийн дунджаар нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хувь хэмжээгээр Худалдаа хөгжлийн банк (39.7 хувь) тэргүүлж, Голомт банк (24.7 хувь) удаалж байна.


Хүснэгт 8. Банкуудад ноогдох чанаргүй зээлийн хэмжээ (хувиар)

	2002-III	2003-III	2004-III	2005-III	Дундаж
Анод	0.9	6.8	12.0	18.5	9.6
Голомт	37.5	17.7	25.3	18.3	24.7
Зоос	0.9	2.4	2.4	3.6	2.3
Интер	0.2	0.1	1.4	0.7	0.6
Капитал	0.1	0.5	0.5	0.5	0.4
Капитрон	-	5.6	3.9	1.7	2.8
Кредит	1.1	0.3	0.2	0.4	0.5
Менатеп	-	-	5.3	3.5	2.2
Шуудан	10.7	3.9	7.3	4.3	6.6
Тээвэр Хөгжил	0.2	3.0	1.8	2.3	1.8
Улаанбаатар	4.0	2.1	4.3	2.1	3.1
Хадгаламж	-	-	1.8	1.6	0.8
Хөдөө Аж Ахуй	0.2	0.6	0.2	6.7	1.9
Хас	0.1	0.3	0.7	0.4	0.4
Худ/хөгжил	44.0	56.5	32.2	26.2	39.7
Чингис Хаан	-	-	-	8.5	2.1
Эрэл	0.2	0.2	0.8	0.7	0.5
Нийт	100.0	100.0	100.0	100.0	100.0

ЗЭЭЛ ОЛГОЛТ, ТӨЛӨЛТ

Банкны салбараас 2005 оны 3 дугаар улирлын байдлаар аж аухйн нэгж, байгууллага, иргэдэд 353.3 тэрбум төгрөгийн зээл олгосон нь өмнөх оны мөн үеэс 56.3 хувь буюу 127.2 тэрбум төгрөг, 2003 оныхоос 2.2 дахин буюу 190.9 тэрбум төгрөг, 2002 оноос 3.3 дахин буюу 247.7 тэрбум төгрөгөөр тус тус өссөн нь санхүүгийн зуучлал гүнзгийрч байгааг харуулж байна. 2005 оны 3 дугаар улиралд олгосон зээлийн 26.4 хувийг үйлдвэрлэлийн салбарт, 73.6 хувийг үйлдвэрлэлийн бус салбарт олгосон байна.

Зураг 5. Олгосон зээлийн өрийн үлдэгдэл, салбараар (тэрбум төг.)




Зураг 5-аас харахад банкууд үйлдвэрлэлийн бус салбарт түлхүү зээл олгодог нь харагдаж байна. Үүн дотроо бөөний болон жижиглэн худалдааны салбар дийлэнх буюу сүүлийн 4 жилийн дунджаар олгосон зээлийн 61.9 хувийг

эээлж байна. Энэ нь банкуудын зээлийн хүү өндөр, хугацаа богино байгаагаас шалтгаалж бизнес эрхлэгчид богино хугацааны, түргэн эргэлдэх арилжаа наймааг сонирхогдогтой холбоотой. Харин үйлдвэрлэлийн зориулалтаар олгосон зээлийн өрийн үлдэгдэлд боловсруулах үйлдвэрийн салбар давамгайлж байна.

Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгож байгаа зээлийн 50-аас дээш хувь буюу нийт үйл ажиллагаа явуулж буй 17 банкны 12 банк нь үйлдвэрлэлийн бус салбарт зээлийг түлхүү олгож байна.

Зураг 6. Төлөгдсөн зээлийн өрийн үлдэгдэл, салбараар (тэрбум төг.)



Төлөгдсөн зээлийн хувьд мөн үйлдвэрлэлийн бус салбараас зээлийн дийлэнх нь эргэн төлөгдсөн үзүүлэлттэй байна. Тухайлбал, 2005 оны 3 дугаар улиралд 73.2 хувь, 2004 онд 63.1 хувь, 2003 онд 70.2 хувь, 2002 онд 55.0 хувь

нь үйлдвэрлэлийн бус салбараас тус тус төлөгджээ. Үүн дотроо зээлийн эргэн төлөлтөөр бөөний болон жижиглэнгийн худалдаа ба бусад салбарууд тэргүүлж байна. Үйлдвэрлэлийн зориулалтын хувьд уул уурхай, олборлох үйлдвэр ба боловсруулах үйлдвэрийн салбар, сүүлийн 2 жилд барилгын салбарын эргэн төлөлт давамгайлж байна.

Сүүлийн 4 жилийн дунджаар нийт олгосон зээлийн 23.2 хувь нь Худалдаа хөгжил, 21.2 хувь Хөдөө аж ахуй, 12.1 хувь нь Голомт, 11.9 хувь нь Анод, 5.9 хувь нь Шуудан, 5.1 хувь Зоос банкинд, үлдсэн 20.6 хувь нь бусад банкуудад ноогдож байна. Үндсэндээ дээрх 6 банк нийт олгосон зээлийн 79.4 хувийг эзэлж байгаа нь зээлийн зах зээлийг ерөнхийдөө тодорхойлж байна. Менатеп банк 2004 оноос хойш зээл олгоогүй байна.

2005 оны 3 улиралд зээлийн эргэн төлөлтийн хувь 85.6 хувь байгаа нь 2002 оны мөн үеэс 9.2 нэгж, 2003 оныхоос 1.1 нэгжээр тус тус бага бөгөөд 2004 оныхоос 1.3 нэгжээр өндөр байна. Төлөгдсөн зээл 2005 оны 3 дугаар улирлын байдлаар 95.9 хувь буюу 290.2 тэрбум төгрөг нь хугацаандаа байгаа зээлээс, 2.0 хувь буюу 6.0 тэрбум төгрөг нь хугацаа хэтэрсэн зээлээс, 2.1 хувь буюу 6.3 тэрбум төгрөг нь чанаргүй зээлээс төлөгдөв.

Сүүлийн 4 жилийн дунджаар нийт төлөгдсөн зээлийн 25.8 хувь нь Худалдаа хөгжил, 17.5 хувь Хөдөө аж ахуй, 14.0 хувь нь Голомт, 10.5 хувь нь Анод, 5.3 хувь нь Шуудан, 4.5 хувь Зоос банкинд, үлдсэн 22.4 хувь нь бусад банкуудад ноогдож байна.

Тайлант улиралд төлөгдсөн нийт зээлийн 26.8 хувь нь үйлдвэрлэлийн зориулалтын салбараас, 73.2 хувь үйлдвэрлэлийн бус салбараас эргэн төлөгджээ. Үүнийг дэд салбаруудаар авч үзэхэд 45.5 хувь бөөний болон жижиглэн худалдаа, 9.6 хувь боловсруулах үйлдвэр, 6.1 хувь барилга, 5.9 хувь нь уул уурхай олборлох үйлдвэр, 32.9 хувь нь үлдсэн бусад салбараас тус тус төлөгдсөн байна.

Хүснэгт 9.Олгосон, төлөгдсөн зээлд эзлэх банкуудын хувь хэмжээ (хувиар)

	2002-III		2003-III		2004-III		2005-III		Дундаж	
	ол/н	төл/н	ол/н	төл/н	ол/н	төл/н	ол/н	төл/н	олгосон	төлсөн
Анод	11.1	9.9	13.5	11.8	15.7	12.5	7.1	8.0	11.9	10.5
Голомт	10.9	10.2	14.5	16.9	12.2	15.4	10.6	13.3	12.1	14.0
Зоос	5.7	5.5	4.5	4.7	3.7	2.2	6.3	5.5	5.1	4.5
Интер	1.3	2.0	3.1	4.7	1.1	2.6	0.4	1.2	1.5	2.6
Капитал	1.8	1.6	1.5	2.2	1.3	1.8	1.8	1.5	1.6	1.8
Капитрон	5.2	3.2	3.6	4.7	2.3	3.9	6.0	5.7	4.3	4.4
Кредит	1.4	0.5	1.5	1.5	0.4	1.3	0.9	0.4	1.0	0.9
Менатеп	-	7.9	0.7	0.6	-	-	-	-	0.2	2.1
Шуудан	5.2	3.1	8.1	7.0	4.9	5.3	5.3	5.9	5.9	5.3
Т/Хөгжил	0.9	1.1	1.4	1.1	1.1	1.0	0.3	0.5	0.9	0.9
Улаанбаатар	3.1	2.5	1.2	1.3	3.3	2.6	5.1	2.9	3.2	2.3
Хадгаламж	3.5	3.0	4.9	4.6	2.2	1.9	4.5	4.6	3.8	3.5
ХААН	18.8	14.1	22.5	17.9	21.4	20.1	22.1	18.0	21.2	17.5
Хас	3.3	2.3	-	-	4.6	4.7	5.5	4.7	3.3	2.9

Худ/хөгжил	26.4	32.0	18.3	20.6	24.6	23.5	23.4	27.2	23.2	25.8
Чин/хаан	-	-	-	-	0.6	0.2	0.4	0.5	0.2	0.2
Эрэл	1.3	1.2	0.7	0.4	0.6	0.9	0.3	0.3	0.7	0.7
Нийт	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0

* Хас банк 2003 оны 3 дугаар улирлын олгосон, төлөгдсөн зээлийн тайлангаа өгөөгүй.

* Чингис хаан банк 2003 оны 10 дугаар сараас банкны үйл ажиллагааны зөвшөөрөл авсан.

Зээлийн тайланг улирал тутам нэгтгэн гаргадаг бөгөөд улирлын хэлбэлзлийг статистикийн декомпозиц аргаар тодорхойлдог ба зарим тохиолдолд улирлын индексүүдийг улирлын давалгаа гэдэг. 2002 оны 1 дүгээр улирлаас 2005 оны 3 дугаар улирал хүртэл олгосон, төлөгдсөн зээл, зээлийн өрийн үлдэгдэлд зээлийн улирлын хэлбэлзлийг декомпозиц аргаар тодорхойлжээ.

Хүснэгт 10. Зээл олголт, төлөлт, зээлийн өрийн үлдэгдэл, улирлаар (тэрбум төгрөг)

Улирал	2002	2003	2004	2005
Зээл олголт				
1	88.7	151.0	235.1	298.0
2	124.0	183.8	260.6	329.2
3	105.9	162.7	226.8	353.3
Дүн	318.6	497.5	722.5	980.5
Зээл төлөлт				
1	72.4	103.6	179.9	227.3
2	84.2	137.9	206.5	251.5
3	100.7	140.9	190.8	302.5
Дүн	257.3	382.4	577.2	781.3
Зээлийн өрийн үлдэгдэл				
1	151.1	279.9	498.5	640.9
2	191.0	327.9	525.5	719.7
3	196.6	352.1	565.8	774.6
Дүн	538.7	959.9	1589.8	2135.2

Зээл олголт, төлөлт, зээлийн өрийн үлдэгдлийн үзүүлэлтүүд улирлаар хэрхэн хувиарлагдаж байгааг харьцангуй байдлаар үзүүлбэл:

Хүснэгт 11. Зээл олголт, төлөлт, зээлийн өрийн үлдэгдэл, улирлын хувиарлалт (хувиар)


Улирал	2002	2003	2004	2005
Зээл олголт				
1	27.8	30.4	32.5	30.4
2	38.9	36.9	36.1	33.6
3	33.2	32.7	31.4	36.0
Дүн	100.0	100.0	100.0	100.0
Зээл төлөлт				
1	28.1	27.1	31.2	29.1
2	32.7	36.1	35.8	32.2
3	39.1	36.8	33.1	38.7
Дүн	100.0	100.0	100.0	100.0
Зээлийн өрийн үлдэгдэл				
1	28.0	29.2	31.4	30.0
2	35.5	34.2	33.1	33.7

3	36.5	36.7	35.6	36.3
Дүн	100.0	100.0	100.0	100.0

Доорхи зурагнууд дээр Х тэнхлэгээр улирлын өсөн нэмэгдэх эрэмбийг (тухайлбал, 2002 оны 1 дүгээр улирал=1, 2002 оны 2 дугаар улирал=2 гэх мэт), Y тэнхлэг дээр тухайн хувьсагдахууны утгыг авсан болно.


Жилийн дундаж абсолют болон харьцангуй өөрчлөлтийг авч үзэхэд зээл олголт жилд дунджаар 15.4 хувь буюу 24.1 тэрбум төгрөгөөр өсч байжээ. Улирлын мэдээтэй холбоотойгоор онцолж хэлэх зүйл гэвэл сүүлийн 4 жил зээл олголт 3 дугаар улиралд (2005 оны 3 дугаар улирлыг эс тоцвол) ямагт буурч байсан байна. Энэ нь магадгүй улирлын хэв шинжтэй үйл ажиллагаа явуулдаг салбаруудын онцлогоос хамаарч болох талтай.

Зураг 7. Зээл олголт (тэрбум төг.)




Төлөгдсөн зээлийн жилийн өсөлт 14.6 хувь буюу 20.9 тэрбум төгрөг байсан байна. Зээл төлөлтийн хувьд сүүлийн 4 жилд зээл төлөлт өсч ирсэн байна (2004 оны 3 дугаар улиралд буурсаныг эс тооцвол).

Зураг 8.Зээл төлөлт (тэрбум төг.)



2002-2005 онуудын 3 дугаар улиралд зээлийн өрийн үлдэгдэл жилд дунджаар 16.7 хувь буюу 56.7 тэрбум төгрөгөөр нэмэгдэж байжээ.

Зураг 9.Зээлийн өрийн үлдэгдэл (тэрбум төг.)



Улирлын мэдээллийг үндэслэсэн трендүүд нь өсөх хандлагатай, мөн банк санхүүгийн салбар эрүүлжиж, тогтворжиж, цаашид энэ байдал үргэжлэснээр зээл олголт, төлөлт, буурахгүй харин ч нэмэгдэнэ гэсэн таамаглалыг үндэслэн улирлын индексүүдийг тэвшитгээгүй өгөгдлийг шууд ашиглаж тооцъё.




Хүснэгт 12. Улирлын хэлбэлзлийн индексийн тооцоо (тэрбум төгрөг, хувиар)

Улирал	2002	2003	2004	2005	4 жилийн дундаж	Улирлын индекс
Зээл олголт						
1	88.7	151.0	235.1	298.0	193.2	30.7
2	124.0	183.8	260.6	329.2	224.4	35.6
3	105.9	162.7	226.8	353.3	212.2	33.7
Дүн	318.6	497.5	722.5	980.5	629.8	100.0
Зээл төлөлт						
1	72.4	103.6	179.9	227.3	145.8	29.2
2	84.2	137.9	206.5	251.5	170.0	34.0
3	100.7	140.9	190.8	302.5	183.7	36.8
Дүн	257.3	382.4	577.2	781.3	499.5	100.0
Зээлийн өрийн үлдэгдэл						
1	151.1	279.9	498.5	640.9	392.6	30.1
2	191.0	327.9	525.5	719.7	441.0	33.8
3	196.6	352.1	565.8	774.6	472.3	36.2
Дүн	538.7	959.9	1589.8	2135.2	1305.9	100.0

Улирлын хэлбэлзлийн индексийн зургаас харахад зээл олголт 2 дугаар улиралд өсөлттэй, 3 дугаар улиралд бууралттай байна. Зээл олголт 2 дугаар улиралд хамгийн дээд түвшиндээ хүрч байгаа бөгөөд ерөнхий дунджаасаа 35.6 хувиар илүү байна. Харин хамгийн бага зээл олголтын хувьд 1 дүгээр улиралд байна.

Зээл төлөлт ба зээлийн өрийн үлдэгдэл хувьд 1-3 улиралд өсөлттэй бөгөөд 3 дугаар улиралд максимумдаа хүрсэн байна.

Зураг 10. Зээл олголт, төлөлт, зээлийн өрийн үлдэгдлийн улирлын индекс (2002-2005 оны мэдээн дээр тулгуурласан тооцоо)



Зээлийн хугацаа

Нийт хугацаандаа байгаа зээлийн өрийн үлдэгдлийн 91.9 хувь, 90.7 хувь, 81.2 хувь нь 2002, 2003, 2004 оны 3 дугаар улиралд 1 хүртэл жилийн хугацаатай зээл байсан бөгөөд 2005 оны мөн үед 75.6 хувь болж буурчээ. Энэ нь банкууд богино хугацаат зээлийг түлхүү олгосныг харуулж байна. Гэвч сүүлийн жилүүдэд урт хугацаат зээл аажмаар нэмэгдэж байгаа нь банкууд гадны эх үүсвэрээр төрөл бүрийн төсөл хэрэгжүүлж байгаатай холбоотой.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад, 1 хүртэл жилийн хугацаатай зээл 26.4 хувь буюу 110.5 тэрбум төгрөг, 1-5 хүртэл жилийн хугацаатай зээл 74.7 хувь буюу 59.5 тэрбум төгрөг, 5 ба түүнээс дээш жилийн хугацаатай зээл 81.9 хувь буюу 14.3 тэрбум төгрөгөөр тус тус өсчээ. Сүүлийн үед банкууд урт хугацааны хөрөнгө оруулалтанд санхүүжилт хийх, үл хөдлөх хөрөнгөөр барьцаалан иргэдэд олгогддог орон сууцны зээл болох ипотек зэрэг урт хугацаат зээлийг олгож эхэлж байна.

2002 оны 3 дугаар улиралтай харьцуулбал, 1 хүртэл жилийн хугацаатай зээл 3.1 дахин, 1-5 хүртэл жилийн хугацаатай зээл 17.4 дахин, 5 ба түүнээс дээш жилийн хугацаатай зээл 4.7 дахин тус тус өсчээ. 2003 оныхоос 82.7 хувь, 7 дахин, 3.2 дахин нэмэгдсэн байна.

Хүснэгт 13.Банкны салбарын хугацаандаа байгаа буюу чанартай зээлийн өрийн үлдэгдэл, хугацааны ангиллаар (тэрбум төг)

	2002-III	2003-III	2004-III	2005-III
1 хүртэл жилийн хугацаатай	166	289.4	418.1	528.6
1-5 хүртэл жилийн хугацаатай	8.0	20.0	79.6	139.1
5 ба түүнээс дээш жилийн хугацаатай	6.7	9.8	17.5	31.8
Нийт хугацаандаа байгаа зээл	180.7	319.2	515.2	699.5

Банкууд 1 хүртэл жилийн хугацаатай ба 5 ба түүнээс дээш жилийн хугацаатай зээлийг үйлдвэрлэлийн бус салбарт, 1-5 хүртэл жилийн хугацаатай зээлийг үйлдвэрлэлийн салбарт түлхүү олгож байна.

Үйл ажиллагаа явуулж байгаа 17 банкнаас сүүлийн 4 жилийн дунджаар 8 банк 1 жилээс дээш хугацаатай зээлийг үйлдвэрлэлийн салбарт олгосон ба 5 банк нь үйлдвэрлэлийн бус салбарт олгожээ. Үлдсэн 4 банк болох Интер, Менатеп, Улаанбаатар, Хадгаламжийн банкууд 1 жилээс дээш хугацаатай зээлийг олгоогүй байна. Тэд зөвхөн богино хугацааны буюу 1 жил хүртэлх хугацаатай зээлийг аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд санхүүжүүлэлтийг хийж байна.

2005 оны 3 дугаар улирлын байдлаар 1 жилээс дээш хугацаатай нийт зээлийн өрийн үлдэгдлийн 20 хувь буюу 34.3 тэрбум төгрөг нь Чингис хаан банк, 17.0 хувь буюу 29.3 тэрбум төгрөг нь Голомт, 16.1 хувь буюу 27.5 тэрбум төгрөг нь Анод, 14.8 хувь буюу 25.3 тэрбум төгрөг нь Хөдөө аж ахуй, 11.1 хувь буюу 19.0 тэрбум төгрөг нь Худалдаа хөгжлийн банкинд ноогдож байгаа нь бусад банкуудаас давамгайлж байна.

Хүснэгт 14².Банкуудын 1 жилээс дээш хугацаатай хугацаандаа байгаа зээлийн өрийн үлдэгдэл (тэрбум төг)

	2002-III		2003-III		2004-III		2005-III		Дундаж	
	Үйлд-н	Үйлд-н бус	Үйлд-н	Үйлд-н бус	Үйлд-н	Үйлд-н бус	Үйлд-н	Үйлд-н бус	Үйлд-н	Үйлд-н бус
Анод	0.8	0.0	0.8	0.3	0.4	1.2	15.3	12.2	4.3	3.4
Голомт	3.0	1.5	2.8	3.1	8.2	12.6	11.8	17.5	6.5	8.7
Зоос	0.3	0.0	1.4	1.1	2.6	1.2	3.1	2.5	1.8	1.2
Интер	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Капитал	0.0	0.0	0.2	0.0	0.0	0.0	2.0	0.1	0.6	0.0
Капитрон	0.0	0.5	0.4	0.3	1.5	1.7	3.3	3.0	1.3	1.4
Кредит	0.4	0.0	0.3	0.0	0.1	0.2	0.2	0.2	0.3	0.1
Менатеп	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Шуудан	0.6	0.0	2.4	1.1	5.5	3.3	5.7	3.0	3.5	1.9
Т/Хөгжил	0.0	0.1	0.0	0.1	0.0	0.3	0.0	0.5	0.0	0.2
Улаанбаатар	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.1	0.0	0.1	0.0	0.0
Хадгаламж	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
ХААН	0.0	0.1	1.6	0.9	0.3	0.5	3.1	22.2	1.2	5.9
Хас	0.2	0.6	0.2	2.7	0.3	1.6	1.4	8.6	0.5	3.4
Худ/хөгжил	3.9	1.1	9.1	0.6	10.2	3.8	14.9	4.1	9.5	2.4
Чин/Хаан	-	-	-	-	22.5	16.1	16.7	17.5	19.6	16.8
Эрэл	1.7	0.0	0.6	0.0	1.3	0.0	1.9	0.2	1.4	0.1
Нийт	10.9	3.8	19.9	10.1	52.9	42.6	79.4	91.6	50.6	45.4

Чингис хаан банкны зээлийн өрийн үлдэгдлийн 99.8 хувь нь 1 жилээс дээш хугацаатай зээл, 0.2 хувь нь 1 хүртэл жилийн хугацаатай зээл байна. Тайлант улиралд банкууд 1 жилээс дээш хугацаатай зээлээ боловсруулах үйлдвэр, бөөний болон жижиглэнгийн худалдаанд олгожээ.

Зээлийн хүү

Зээлийн хүүгийн түвшинд Төв банкны үнэт цаасны хүү, хэрэглээний үнийн индексийн өөрчлөлт, мөнгөний нийлүүлэлт, татварын дарамт зэрэг олон хүчин зүйлс нөлөөлдөг. Төв банкны зүгээс мөнгөний бодлогын хэрэгслүүдээрээ дамжуулан хүүнд шууд бус замаар нөлөөлдөг. Гэвч хүү нь зах зээлийн жам ёсоор зээлийн эрэлт нийлүүлэлтийн дагуу өөрчлөгдөж явдаг. Төв банкны зүгээс хүүнд шууд нөлөөлөх боломжоор хязгаарлагдмал тул санхүүгийн салбарын хөгжлийг дэмжих, зээлийн эх үүсвэрийг өсгөх, санхүүгийн өрсөлдөөнийг бий болгох, гадаадын хөрөнгө оруулалтыг түлхүү оруулах тал дээр бодлогын арга хэмжээ авч хэрэгжүүлж байна.

Банкуудын 1 жил хүртэл хугацаатай зээлийн хүү нь 2005 оны 3 дугаар улирлын байдлаар дунджаар 42.0 хувьтай байгаа нь 2002, 2004 оноос 3.0 нэгж, 2003 оныхоос 0.5 нэгжээр тус тус өсчээ. 1-5 хүртэл жилийн хугацаатай зээлийн хүү 2002 оноос 16.6 нэгж, 2003, 2004 оноос 19.8 нэгжээр өсч, 2005 оны 3 дугаар улиралд 57.6 хувь болов. 5 ба түүнээс дээш хугацаатай зээлийн хүү 2003 оноос 15.5 нэгжээр буурч, 2004, 2005 онд ижил 17.8 хувьд хүрэв. Зээлийн хүү өндөр

² Хүснэгт 11-д 1-5 жилийн хугацаатай зээл болон 5 ба түүнээс дээш хугацаатай зээлийг хамтад нь авч, 1 жилээс дээш хугацаатай зээл гэж нэрлэв.

байгаа нь банкуудын эх үүсвэрийн зардал болон үйл ажиллагааны зардалтай холбоотой. Санхүүгийн байгууллагууд эх үүсвэрийн төлөө хадгаламжийн өндөр хүү амлаж байгаа, мөн татварын түвшин өндөр байгаа нь банкуудын зардлыг өсгөж байна.

Харин үйлдвэрлэлийн салбарт олгосон банкуудын зээлийн дундаж хүү 2002 оны 3 дугаар улирлаас 12.5 нэгж, 2003 оноос 10.4 нэгж, 2004 оныхоос 6.5 нэгжээр тус тус буурч жилийн дундаж хүү 29.5 хувь болов. Үйлдвэрлэлийн бус салбарын хувьд 2005 оны 3 дугаар улирлын байдлаар зээлийн дундаж хүү 27.0 хувь байгаа нь (2004 оноос бусад) 2002, 2003 онуудаас 12, 13.8 нэгжээр тус тус буурсан байна.

Өнөөгийн байдлаар банкны салбар эрүүлжиж, тогтвортой байгаа ч зарим банкуудын хувьд өмнөх банкны хямралаас үүдсэн болгоомжлол байж, эх үүсвэрээ эрсдэл багатай хөрөнгөнд байршуулахыг илүүд үзэн, энэ нь зээлийн нийлүүлэлтийг тодорхой хэмжээгээр багасган хүүнд нөлөөлдөг байж болох талтай. Зарим банкууд зөвхөн найдвартай гэж үзсэн цөөн хэдэн зээлдэгчдэд хүүгээ бууруулах бодлогыг баримталж байна.

Хүснэгт 15. Банкуудын зээлийн хүү (хувиар)

	2002-III		2003-III		2004-III		2005-III	
	дундаж	дээд, доод	дундаж	дээд, доод	дундаж	дээд, доод	дундаж	дээд, доод
1 хүртэл жилийн хуг-тай	39.0	6.0-72.0	41.5	11.0-72.0	39.0	6.0-72.0	42.0	12.0-72.0
1-5 хүртэл жилийн хуг-тай	41.0	22.0-60.0	37.8	9.6-66.0	37.8	9.6-60.0	57.6	9.6-48.0
5 ба түүнээс дээш жилийн хуг-тай	7.8	7.8	33.3	7.8-58.8	17.8	12.0-23.5	17.8	12.0-23.5
Үйлдвэрлэлийн зориулалтаар	42.0	12.0-72.0	39.9	7.8-72.0	36.0	18.0-54.0	29.5	11.0-48.0
Үйлдвэрлэлийн бус зориулалтаар	39.0	6.0-72.0	40.8	9.6-72.0	24.0	6.0-42.0	27.0	6.0-48.0

Дүгнэлт

Банкны дараалсан хямралыг гэтлэн давж банкны бүтцийн өөрчлөлт, шаардлагатай арга хэмжээнүүдийг Монголбанк авч хэрэгжүүлснээр банкны салбарын ажиллагаа эрүүлжин тогтворжиж, санхүүгийн зуучлал гүзгийрсэн, хадгаламжийн хэмжээ өсч, иргэдийн банкинд итгэх итгэл³ нэмэгдсээр байна. Сүүлийн жилүүдэд эдийн засаг дахь мөнгө асар хурдацтай өссөн нь үгүйлэгдэж байсан санхүүгийн зуучлал хэвийн явагдах болж иргэд банкин дахь хадгаламжаа нэмэгдүүлснээр банкуудын зээл олгох эх үүсвэр өсч, зээл, түүний барьцаа тойрсон хууль эрх зүйн орчин чангарсан, төрийн мэдлийн банкууд хувьчлагдаж банкууд эзэнтэй болсноор банкуудын үйл ажиллагаа сайжирч, өрсөлдөөн улам нэмэгдэж, бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл нь ихсэж байна.

³ Монголбанкнаас 2005 онд явуулсан Монгол улсын нийгэм, эдийн засаг, банк санхүүгийн байгууллагын хөгжил, үйл ажиллагааны талаархи түүвэр судалгаанд хамрагдсан иргэдийн 49.9 хувь нь бнк санхүүгийн салбарын үйл ажиллагаа найдвартай гэж үзсэн байна. Энэ нь 2003 оныхоос 4.1 хувиар өссөн байна.

Зээлийн хэмжээ, тоо, төрөл нэмэгдсэн ч иргэд, байгууллагын хувьд зээлийн эрэлт нь урьдын адил өндөр хэвээр байна. 2005 онд Монголбанкнаас явуулсан нийгэм эдийн засгийн түүвэр судалгаанд хамрагдсан иргэдийн 83.5 хувь зээлийн хэрэгцээ их байдаг гэж хариулсан нь үүнийг нотолж байна. Мөн манай улсад хөрөнгийн захын хөгжил сул дорой байгаагаас бизнес эрхлэгчдийн хувьд санхүүгийн эх үүсвэр олж авах боломж хязгаарлагдаж, банкны салбарт ачаалал хэт төвлөрч байна. Иймээс банкууд зээлийн хүүгээ бууруулах сонирхолгүй, нөгөөтэйгүүр сүүлийн жилүүдэд их хэмжээгээр бий болж буй ББСБ, ХЗХ-ын эх үүсвэрийн төлөөх тэмцэл, татварын дарамт нь хүүний түвшинг өндөр хэвээр байлгахад нөлөөлж байна.

Банк санхүүгийн зах зээлийн байдал болон зээлийн эрэлт, нийлүүлэлтээс шалтгаалан зээлийн хүүг тогтоодог гол байгууллага арилжааны банкууд юм. Зээлийн хүүгээ бууруулах нь жижиг банкуудын хувьд ашиггүй байгаа учраас тэд зээлийн хүүгээ өөрчлөхийг хүсэхгүй. Хэдийгээр бусад банкууд зээлийн хүүгээ буурууллаа ч тэд эрэлтийг бүрэн хангаж чадахгүй учраас банкуудын хувьд зээлдэгч олдсоор байх ба өөр ямар нэгэн өрсөлдөгч байхгүй тохиолдолд хүүгээ бууруулахгүй нь ойлгомжтой. Гэвч цаашид зээлийн хүү буурахын хэрээр жижиг банкуудын зардал өссөний улмаас ашиг нь зайлшгүй буурч үүний үр дүнд банкууд зарим нэг зардлаа хэмнэх үүднээс нэгдэх хандлага бий болно гэж хэлж болно.

Банкуудын зээлжүүлэлтийн дийлэнх нь үйлдвэрлэлийн бус салбарт чиглэгдэж байгаа нь дээрх судалгаанаас харагдаж байна. Цаашид банкууд зээлийн хүүгээ бууруулах, хугацааг уртасгах, нэр төрлийг нэмэгдүүлснээр урт болон дунд хугацааны зээлжүүлэлтийг, ялангуяа үйлдвэрлэлийн салбарыг хөгжүүлэхэд анхаарах хэрэгтэй болж байна. Ингэснээр ядуурлаас гарах, ажилгүйдлийг багасгах, эдийн засгийн өсөлтийг хангахад бага боловч хувь нэмэр оруулах болно.